



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 30 өдөр

Дугаар A/04

Улаанбаатар хот

“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах салбар зөвлөлийн
бүрэлдэхүүн”-ийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”-ын 6 дугаар зүйлийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус II хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Багахангай дүүргийн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг хавсралтаар баталсугай.

2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (М.Давааням)-д даалгасугай.


3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн A/21 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2015 оны 01 дүгээр сарын 30 -ны өдрийн 4109 дүгээр тогтоолын хавсралт



ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

Гишүүд

Дүүргийн Засаг дарга

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эрх зүй, төрийн байгуулалтын хорооны дарга

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга

Налайх, Багахангай дүүргийн Прокурорын газрын Ерөнхий прокурор

Багахангай, Налайх дүүргийн шүүхийн Тамгын газрын дарга

Цагдаагийн хэлтсийн дарга

Онцгой байдлын хэлтсийн дарга

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга

Боловсролын хэлтсийн дарга

1 дүгээр хорооны Засаг дарга

2 дугаар хорооны Засаг дарга

“Багахангайн теле камерын хяналтын дэд төв”-ийн дарга

Дотоодын цэргийн 824 дүгээр тусгай салбарын захирагч

Нарийн бичгийн дарга

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн Ажлын албаны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан